



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛ ГЕРМАНЫ ХАМТАРСАН АШИГТ МАЛТМАЛ, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/39/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Сэржмядаг
Утас: 261628 Цахим хаяг: serjmyadags@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Долгоржав
Утас: 261740 Цахим хаяг: dolgorjavb@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Юнистар аудит ХХК
Захирал: М.Энхжаргал
Утас: 11-328735 Цахим хаяг: info@unistaraudit.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
3. Аудитын тайлан.....	15
3.1 Ерөнхий зүйл.....	15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	16
3.4 Материаллаг байдал	16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18
3.8 Аудитын гол асуудал	19
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	20
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
4. Аудитын илрүүлэлт	21
4.1 Залруулсан алдаа	21
4.4 Зөвлөмж.....	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ ГЕРМАНЫ ХАМТАРСАН
АШИГТ МАЛТМАЛ, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Б.БАТЦЭНГЭЛ ТАНАА

20220224 № 07/290
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	685,416,558.47	1,280,648,348.46
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	6,227,359.00	5,636,700.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	6,227,359.00	5,636,700.00
3121	Төгрөг	6,227,359.00	5,636,700.00
31213	Арилжааны банкин дахь харилцах	1,384,459.00	-
31214	Бусад төсөл нөөцийн харилцах	4,842,900.00	5,636,700.00
33	АВЛАГА	612,266,565.22	945,882,548.30
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	315,884.52	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	72,667,700.00	492,439,617.00
33300	Татаас санхүүжилтийн авлага	536,886,100.41	439,368,805.35
335	Бусад авлага	2,396,880.29	14,074,125.95
3351	Байгууллагаас авах авлага	2,396,880.29	14,074,125.95
34	УРЬДЧИЛГАА	55,111,021.00	273,843,081.16
34600	Урьдчилж гарсан зардал	53,694,321.00	273,843,081.16
3471	Урьдчилгаа тооцоо	1,416,700.00	-
34713	Цалингийн урьдчилгаа	1,416,700.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	11,811,613.25	55,286,019.00
354	Хангамжийн материал	11,811,613.25	55,286,019.00
35410	Бичиг хэргийн материал	5,809,200.00	8,548,000.00
35440	Түлш шатах тослох материал	1,766,366.00	2,911,480.00
35450	Барилгын засварын материал	4,236,047.25	6,725,006.50
35470	Бусад хангамжийн материал	-	37,101,532.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	17,109,927,872.13	16,680,746,200.96
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	17,109,927,872.13	16,680,746,200.96
392	Биет хөрөнгө	14,664,533,471.32	14,128,019,550.23
39201	Барилга, байгууламж	12,735,456,358.82	12,735,456,358.82
39202	Хуримтлагдсан элэгдэл	(475,911,511.56)	(713,867,267.40)
39203	Авто тээврийн хэрэгсэл	399,310,674.00	399,310,674.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(278,644,305.70)	(331,479,884.74)
39205	Машин, тоног төхөөрөмж	2,207,917,180.77	2,357,725,782.57
39206	Хуримтлагдсан элэгдэл	(987,184,469.19)	(1,340,364,086.84)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	773,804,443.33	832,331,000.79
39208	Хуримтлагдсан элэгдэл	(444,759,632.96)	(510,721,705.90)
39209	Зам гүүрийн барилга байгууламж	271,126,627.50	271,126,627.50
39210	Хуримтлагдсан элэгдэл	(36,630,492.00)	(54,945,738.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	324,807,415.00	324,807,415.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(203,008,415.61)	(234,703,979.49)
39217	Номын фонд	378,249,598.92	393,344,353.92
393	Биет бус хөрөнгө	2,445,394,400.81	2,552,726,650.73
39301	Програм хангамж	181,462,552.81	181,462,552.81
39302	Хасагдуулга	(5,710,152.00)	(59,381,902.08)

39303	Бусад биет бус хөрөнгө	2,273,675,000.00	2,435,675,000.00
39304	Хасагдуулга	(4,033,000.00)	(5,029,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	17,795,344,430.60	17,961,394,549.42
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	53,945,788.54	78,183,955.32
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	53,945,788.54	78,183,955.32
413	Өглөг	4,988,287.54	-
4136	Бусад өглөг	4,206,000.00	-
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	782,287.54	-
41361	Байгууллагад төлөх өглөг	4,206,000.00	-
414	Урьдчилж орсон орлого	48,957,501.00	78,183,955.32
41440	Бусад урьдчилж орсон орлого	48,957,501.00	78,183,955.32
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	17,741,398,642.06	17,883,210,594.10
51	Засгийн газрын хувь оролцоо	17,741,398,642.06	17,883,210,594.10
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	2,904,539,547.50	2,904,539,547.50
51101	Өмч: -Төрийн өмч	2,904,539,547.50	2,904,539,547.50
512	Хуримтлагдсан үр дүн	12,694,976,232.79	12,836,788,184.83
51210	Өмнөх үеийн үр дүн	12,694,976,232.79	12,694,976,232.79
51220	Тайлант үеийн үр дүн	-	141,811,952.04
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,141,882,861.77	2,141,882,861.77
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	17,795,344,430.60	17,961,394,549.42

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,980,457,871.80	4,021,844,749.78
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,731,854,538.80	1,701,677,620.24
120	Нийтлэг татварын бус орлого	1,731,854,538.80	1,701,677,620.24
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,628,867,868.69	1,701,677,620.24
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	828,973,600.00	1,185,526,523.00
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,245,266.80	25,260,145.30
120004 5	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	798,649,001.89	490,890,951.94
120009	Бусад орлого	102,986,670.11	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,248,603,333.00	2,320,167,129.54
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,771,862,500.00	1,868,558,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,771,862,500.00	1,868,558,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	476,740,833.00	451,608,729.54
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	366,753,916.00	415,599,729.54
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	19,408,917.00	10,750,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	90,578,000.00	25,259,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	3,634,826,784.99	3,880,032,797.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,634,826,784.99	3,880,032,797.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,211,691,581.88	3,581,844,709.20
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,639,828,187.65	1,823,467,471.22
210101	Цалин	1,639,828,187.65	1,823,467,471.22
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	204,872,458.29	237,310,557.61
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	142,806,242.41	172,043,942.26
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	15,815,969.49	16,684,337.09
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	12,412,752.54	12,750,919.91
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	3,038,286.17	3,664,513.70
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	30,799,207.68	32,166,844.65
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	213,617,699.12	206,785,471.19
210301	Гэрэл цахилгааны зардал	47,559,997.00	51,029,237.85
210302	Түлш, халаалтын зардал	125,175,422.12	118,492,339.34
210303	Цэвэр, бохир усны зардал	9,524,954.00	10,322,294.00
210304	Байрны түрээс	31,357,326.00	26,941,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	98,491,427.02	176,092,234.94
210401	Бичиг хэргийн материал	12,007,012.00	4,154,920.00
210402	Тээвэр, шатахууны зардал	16,831,838.00	16,115,666.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	21,513,673.52	25,017,398.76
210404	Ном, хэвлэлийн зардал	185,000.00	1,165,156.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	3,536,300.00	743,000.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	44,417,603.50	4,777,951.32
210409	Бараа материал шилжүүлсний зардал	-	124,118,142.86
2105	Нормативт зардал	110,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	110,000.00	-

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	51,814,369.75	32,602,495.75
210601	Багаж хэрэгсэл	877,950.00	808,500.00
210602	Тавилга	1,287,991.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	-	9,422,000.00
210604	Урсгал засвар	49,648,428.75	22,371,995.75
2107	Томилолт, зочны зардал	3,798,042.00	4,501,500.00
210702	Дотоод томилолтын зардал	3,798,042.00	4,501,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	147,461,776.00	210,323,315.95
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	134,344,265.00	193,587,994.78
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	11,000,000.00	11,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	1,477,311.00	5,253,731.17
210804	Тээврийн хэрэгслийн татвар	640,200.00	481,590.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	851,697,622.05	890,761,662.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	959,500.00	-
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	164,176,996.74	45,856,333.11
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	686,561,125.31	844,905,329.43
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	423,135,203.11	298,188,088.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	604,000.00	216,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	604,000.00	216,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	422,531,203.11	297,972,088.54
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	418,723,307.36	297,972,088.54
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,807,895.75	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	345,631,086.81	141,811,952.04
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	956,003,645.88	-
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал	956,003,645.88	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	(956,003,645.88)	-
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(610,372,559.07)	141,811,952.04

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	/төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,904,539,547.50	2,141,882,861.77	13,302,926,201.86	18,349,348,611.13
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	2,422,590.00	2,422,590.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,904,539,547.50	2,141,882,861.77	13,305,348,791.86	18,351,771,201.13
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	(610,372,559.07)	(610,372,559.07)
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,904,539,547.50	2,141,882,861.77	12,694,976,232.79	17,741,398,642.06
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,904,539,547.50	2,141,882,861.77	12,694,976,232.79	17,741,398,642.06
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	141,811,952.04	141,811,952.04
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,904,539,547.50	2,141,882,861.77	12,836,788,184.83	17,883,210,594.10

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,368,528,161.30	3,655,068,490.27
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	847,724,247.80	795,915,260.32
120	Нийтлэг татварын бус орлого	847,724,247.80	795,915,260.32
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	847,724,247.80	795,915,260.32
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	846,478,981.00	794,981,060.32
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,245,266.80	934,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,520,803,913.50	2,859,153,229.95
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,771,862,500.00	1,868,558,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,771,862,500.00	1,868,558,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	748,941,413.50	990,594,829.95
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	634,907,347.25	954,585,829.95
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	19,408,917.00	10,750,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	94,625,149.25	25,259,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	3,279,507,469.30	3,621,347,618.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,279,507,469.30	3,621,347,618.27
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,319,486,165.78	2,883,790,724.38
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,641,955,509.15	1,832,008,626.42
210101	Үндсэн цалин	1,641,955,509.15	1,832,008,626.42
2102	Ажил олгочоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,030,505.58	216,377,495.79
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	62,961,305.25	166,493,522.64
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	4,341,202.53	8,717,317.18
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,262,151.83	6,905,345.51
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	889,153.83	1,655,862.71
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	30,576,692.14	32,605,447.75
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	213,647,699.12	206,745,471.19
210301	Гэрэл цахилгааны зардал	47,559,997.00	51,029,237.85
210302	Түлш, халаалтын зардал	125,175,422.12	118,492,339.34
210303	Цэвэр, бохир усны зардал	9,554,954.00	10,282,294.00
210304	Байрны түрээс	31,357,326.00	26,941,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	64,571,519.02	59,721,131.76
210401	Бичиг хэрэг	6,385,655.00	5,938,000.00
210402	Тээвэр, шатахуун	14,563,500.00	17,078,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,513,673.52	25,017,398.76
210404	Ном, хэвлэл	185,000.00	7,084,671.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,831,300.00	1,291,980.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,092,390.50	3,311,082.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	74,216,330.00	309,263,800.00
210601	Багаж техник хэрэгсэл	38,874,900.00	808,500.00
210603	Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл	-	13,422,000.00
210604	Урсгал засвар	35,341,430.00	295,033,300.00
2107	Томилолт, зочны зардал	4,481,892.00	4,501,500.00

210702	Дотоод албан томилолт	4,481,892.00	4,501,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	148,207,921.00	204,628,680.11
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	133,881,701.00	185,806,070.11
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	11,000,000.00	11,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,686,020.00	7,341,020.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	640,200.00	481,590.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	70,374,789.91	50,544,019.11
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	70,374,789.91	50,544,019.11
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	960,021,303.52	737,556,893.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	604,000.00	216,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	604,000.00	216,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	959,417,303.52	737,340,893.89
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	418,723,307.36	297,972,088.54
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	540,693,996.16	439,368,805.35
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	89,020,692.00	33,720,872.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	86,955,833.00	34,311,531.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	86,955,833.00	34,311,531.00
2200	Дотоод эх үүсвэрээр	86,955,833.00	34,311,531.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	86,955,833.00	34,311,531.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(86,955,833.00)	(34,311,531.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2,064,859.00	(590,659.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,162,500.00	6,227,359.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,227,359.00	5,636,700.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/				
Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	6,227,359.00	(6,227,359.00)
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,492,558,400.00	2,367,092,230.78	125,466,169.22
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,492,558,400.00	2,367,092,230.78	125,466,169.22
210	Бараа, үйлчилгээний зардал	2,491,902,400.00	2,366,876,230.78	125,026,169.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,699,200,700.00	1,659,209,845.42	39,990,854.58
210101	Үндсэн цалин	1,699,200,700.00	1,659,209,845.42	39,990,854.58
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	229,392,100.00	195,561,359.79	33,830,740.21
210201	Тэтгэврийн даатгал	161,424,100.00	145,677,386.64	15,746,713.36
210202	Тэтгэмжийн даатгал	16,992,000.00	8,717,317.18	8,274,682.82
210203	ҮОМШӨ ний даатгал	13,593,600.00	6,905,345.51	6,688,254.49
210204	Ажилгүйдлийн даатгал	3,398,400.00	1,655,862.71	1,742,537.29
210205	Эрүүл мэндийн даатгал	33,984,000.00	32,605,447.75	1,378,552.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	216,594,000.00	206,745,471.19	9,848,528.81
210301	Гэрэл цахилгаан	46,557,000.00	51,029,237.85	(4,472,237.85)
210302	Түлш, халаалт	113,037,000.00	118,492,339.34	(5,455,339.34)
210303	Цэвэр, бохир ус	20,240,000.00	10,282,294.00	9,957,706.00
210304	Байрны түрээс	36,760,000.00	26,941,600.00	9,818,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	95,661,200.00	74,110,951.76	21,550,248.24
210401	Бичиг хэрэг	6,675,900.00	5,938,000.00	737,900.00
210402	Тээвэр (шатахуун)	20,801,200.00	17,078,000.00	3,723,200.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	30,728,200.00	25,017,398.76	5,710,801.24
210404	Ном, хэвлэл	22,359,000.00	21,474,491.00	884,509.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,532,400.00	1,291,980.00	1,240,420.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	12,564,500.00	3,311,082.00	9,253,418.00
2106	Эд хогшил худалдан авах	44,619,200.00	42,120,300.00	2,498,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	13,422,000.00	13,422,000.00	-
210604	Урсгал засвар	31,197,200.00	28,698,300.00	2,498,900.00
2107	Томилот, зочны зардал	5,092,000.00	238,500.00	4,853,500.00
210702	Дотоод албан томилолт	5,092,000.00	238,500.00	4,853,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	146,996,200.00	138,345,783.51	8,650,416.49
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	127,957,500.00	119,523,173.51	8,434,326.49
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	11,000,000.00	11,000,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	7,342,000.00	7,341,020.00	980.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	696,700.00	481,590.00	215,110.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	54,347,000.00	50,544,019.11	3,802,980.89

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	54,347,000.00	50,544,019.11	3,802,980.89
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	656,000.00	216,000.00	440,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	656,000.00	216,000.00	440,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	656,000.00	216,000.00	440,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,492,558,400.00	2,366,501,571.78	126,056,828.22
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,868,558,400.00	1,570,586,311.46	297,972,088.54
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,868,558,400.00	1,570,586,311.46	297,972,088.54
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	624,000,000.00	795,915,260.32	(171,915,260.32)
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	624,000,000.00	794,981,060.32	(170,981,060.32)
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	934,200.00	(934,200.00)
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	6,227,359.00	(6,227,359.00)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	5,636,700.00	(5,636,700.00)
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	72	68	4
620001	Удирдах ажилтан	5	3	2
620002	Гүйцэтгэх ажилтан	47	45	2
620003	Үйлчлэх ажилтан	20	20	-
63	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	72	68	4
65	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч /ТҮ/	72	68	4

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	990,594,829.95
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	990,594,829.95
210	Бараа, үйлчилгээний зардал	-	551,226,024.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	172,798,781.00
210101	Үндсэн цалин	-	172,798,781.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	20,816,136.00
210201	Тэтгэврийн даатгал	-	20,816,136.00
2106	Эд хогшил худалдан авах	-	284,988,276.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	18,653,276.00
210604	Урсгал засвар	-	266,335,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	4,263,000.00
210702	Дотоод албан томилолт	-	4,263,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	-	68,359,831.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	68,359,831.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	439,368,805.35
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	439,368,805.35
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	439,368,805.35
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	990,594,829.95
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	990,594,829.95
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	954,585,829.95
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	10,750,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажилагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	25,259,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Монгол Германы хамтарсан 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, үндсэн хөрөнгийн бүртгэл, үнэлгээг стандартад нийцүүлэхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Үндэсний аудитын газрын захиалгаар Юнистар аудит ХХК-ийн аудитын баг гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Н.Болормаа хэрэгжүүлсэн.

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 01/47 дугаар тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн зорилго нь олон улсын боловсролын сайн туршлага, тэргүүлэх стандартыг Монгол Улсад хэрэгжүүлж, улс орны нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулан, өндөр мэргэшсэн, нийгмийн хариуцлагатай, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, бүтээлч инженерүүдийг бэлтгэх сургалтын үйл ажиллагаа явуулдаг боловсролын байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” 190 дүгээр тушаал;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль нь Захирлын 2020 оны 12 дугаар сарын 01-ний А/115 тоот тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрддөг ба уг бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуульд санхүүжүүлэгч дээд байгууллага болох Боловсрол шинжлэх ухааны яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас дотоод аудит, хяналт үнэлгээ хийгээгүй.

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн захирлын баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалт зохион байгуулах ажлын хэсэг нь

байгууллагын дотоод үйл ажиллагаанд хяналт хийж хууль тогтоомжтой нийцсэн байна гэж үнэлэлт өгсөн байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 3,980,457.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 39,804.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,050.1 мянган төгрөгөөр буюу 0.2 хувиар өсөж, материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилгаа, бараа материал, өр төлбөр нэмэгдэж, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3
Мөнгөн хөрөнгө	6,227.4	5,636.7	(590.7)
Авлага	612,266.6	945,882.5	333,616.0
Урьдчилгаа	55,111.0	273,843.1	218,732.1
Бараа материал	11,811.6	55,286.0	43,474.4
Үндсэн хөрөнгө	14,664,533.5	14,128,019.6	(536,513.9)
Биет бус хөрөнгө	2,445,394.4	2,390,726.7	(54,667.8)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	17,795,344.4	17,799,394.5	4,050.1
Өр төлбөр	53,945.8	78,184.0	24,238.2
Засгийн газрын оролцоо	2,904,539.5	2,904,539.5	-
Хуримтлагдсан үр дүн	12,694,976.2	12,674,788.2	(20,188.0)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,141,882.9	2,141,882.9	-
НИЙТӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	17,795,344.4	17,799,394.5	4,050.1

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны өмнөх оны үлдэгдлээс зарцуулж 590.7 мянган төгрөгөөр буурсан;
- Авлага данс сургалтын төлбөрийн болон татаас санхүүжилтийн 319,541.9 мянган төгрөгөөр, татвар нийгмийн даатгалын байгууллагаас авах авлага 14,074.1 мянган, нийт 333,616.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн;
- Урьдчилж гарсан зардал данс сургуулийн дотуур байрны фасадны засвар үйлчилгээний зардлыг хуримтлуулсан 218,732.1 мянган төгрөгөөр өссөн;
- Бараа материалын данс ашиглалтанд байгаа бараа материалыг бүртгэсэнтэй холбоотойгоор 43,474.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн;
- Үндсэн хөрөнгө данс тайлант оны элэгдлийн зардлаас голлон шалтгаалж 536,513.9 мянган төгрөгөөр буурсан;
- Биет бус хөрөнгө нь тайлант жил 54,667.8 мянган төгрөгийн байгуулсан хорогдлоор буурсан;
- Өр төлбөр данс сургалтын төлбөрийн орлого 24,238.2 мянган төгрөгөөр өссөн;
- Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл өөрчлөлт ороогүй. Хуримтлагдсан үр дүн данс тайлант алдагдал 20,188.0 мянган төгрөгөөр буурсан.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,909,042.0 мянган төгрөгөөр, үүнээс урсгал зардалд 3,905,042.0 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулалд 4,000.0 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Сангийн яамнаас төсвийн шууд захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,373,696.2 мянган төгрөгөөр бууруулан төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,535,345.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор нийт зарлагыг 42,787.4 мянган төгрөгөөр бууруулж 2,492,558.4 мянган төгрөгөөр тодотгож баталсан байна.

Үүнээс хичээл сургалтыг цахимаар хийхтэй холбоотойгоор шуудан холбоо, интернэтийн төлбөр 8,708.2 мянган төгрөг, ном хэвлэл 4,443.5 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардал 7,194.5 мянган төгрөг, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл 13,422.0 мянган төгрөг, урсгал зардал 4,711.8 мянган төгрөгөөр нэмэгдэж хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардал 38,480.0 мянган төгрөгөөр буурсан.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,492,558.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,868,558.4 мянган төгрөгийг улсын төсвөөс 624,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,570,586.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 795,915.3 мянган төгрөг, нийт 2,366,501.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,367,092.3 мянган төгрөгийг зарцуулж 297,972.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, 590.7 мянган төгрөгөөр мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нэмэгдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,367,092.2 мянган төгрөг буюу 95.0 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 73,821.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 9,848.5 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 21,550.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 8,650.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсвийг дутуу зарцуулсан нь Ковид-19 цар тахалтай холбоотой төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээний улмаас байгууллагын үйл ажиллагаа хумигдсан, зарим ажилтан зайнаас ажилласан зэрэг нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөг/

Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Код	Нэр				
71803	Монгол германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн дээд боловсрол	2,492,558.4	2,367,092.2	(125,466.2)	95.0
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,388,740.6	2,268,724.9	(120,015.7)	95.0
80205	Мэдээлэл сурталчилгааны зардал	17,331.8	17,331.8	-	100.0
80219	Харуул хамгаалалтын зардал	32,400.0	32,350.0	(50.0)	99.8
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	53,430.0	48,469.5	(4,960.5)	90.7
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	656.0	216.0	(440.0)	32.9
	Дүн	2,492,558.4	2,367,092.2	(125,466.2)	95.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд өмнөх оны татан төвлөрүүлсэн үлдэгдэл 536,886.1 мянган төгрөг, гадаад, дотоод төсөл хөтөлбөрийн 415,599.7 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 10,750.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоор 25,259.0 мянган төгрөг, урьдчилж төлсөн зардал тооцоогоор 2,100.0 мянган төгрөг, нийт 990,594.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин нийгмийн даатгалын зардалд 193,614.9 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 284,988.3 мянган төгрөг, томилолт, зочны зардалд 4,263.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 68,359.8 мянган төгрөг, нийт 551,226.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 439,368.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монгол Германы ашигт малтмал, технологийн их сургууль нь төсвийн жилд дээд боловсролын 1 хөтөлбөр, 5 арга хэмжээний нийт 10 зорилтын хүрээнд дараах үр дүнд хүрэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг тайлагнаж, харьяа дээд байгууллага болох Боловсрол шинжлэх ухааны яамны хяналт шинжилгээ үнэлгээний газар 91.6 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлжээ.

Тайлант онд тус сургуулийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөр, 5 арга хэмжээний хэрэгжилт 91.3 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 95.0 хувийн биелэлттэй, 3.7 хувиар зөрүүтэй буюу төсвийг хэмнэлттэй зарцуулж байгууллагын хүрэх үр дүнд хүрч ажилласан байна.

3.8 Аудитын гол асуудал

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн захирлын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны А/06 тоот тушаалаар Худалдан авах үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө батлуулж нийтэд мэдээлсэн байна. Уг төлөвлөгөөний дагуу тендер зарлаж 400.0 сая төгрөгийн худалдан авалт хийж шилэн дансанд байршуулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль нь 2021 онд нийт 4,160,025.4 мянган төгрөгийн 98 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 13 мэдээллийг ил тод байршуулаагүй, орлогын 856,549.7 мянган төгрөгийн нийт 14 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална” 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх” 4.1.2 “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх” 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.2 “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд “Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага” хүргүүлнэ гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул хариуцсан албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 509,865.8 мянган төгрөгийн 2 алдаа зөрчил илрүүлснээс 509,865.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгч жилийн эцсийн аудитаар дахин хянахад бүрэн хэрэгжээгүй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 13,865.5 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай, шилэн дансны тухай хуулийг хэрэгжилт хангалтгүй зөрчилд өгсөн албан шаардлагын биелэлт 87 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	0.0	1	0.0	-	-	87.0
Зөвлөмж	2	13,865.5	2	13,865.5	-	-	100.0
Нийт дүн	3	13,865.5	3	13,865.5	-	-	93.5

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус сургуульд хэрэгжүүлж буй гадаадын болон дотоодын бусад эх үүсвэрээс нэмэлт санхүүжилтээр хэрэгжиж байгаа судалгааны төслүүдийн төсвийн зарцуулалт, тайлагналыг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 453,442.9 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, 439,368.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 14,074.1 мянган төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 14,074.1 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшин 39,804.6 мянган төгрөгөөс 25730.5 мянган төгрөгөөр бага тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаанд нэг залруулга хийж санхүүгийн тайланд тусгаж баталгаажуулав. Үүнд:

Тус байгууллага нь нэмэлт санхүүжилтийн орлогоос төвлөрүүлсэн 439,368.8 мянган төгрөгийг зардлын дансанд бүртгэснийг залруулж авлага дансанд бүртгэв.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих дараах асуудлаар зөвлөмж өгөв. Үүнд:

1. Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Налайх дүүргийн нийгмийн даатгалын хэлтсээс 7,360.4 мянган төгрөг, нийслэлийн татварын газраас авах суутган 6,713.7 мянган төгрөгийн илүү тооцоолж бүртгэсэн 14,074.5 мянган төгрөгийн авлага байна.

Энэ нь үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Харилцагч тус бүрээр авлагын тооцоо нийлж, актаар баталгаажуулан, авлагаа барагдуулж, авлага, өглөг үүсгэхгүй ажиллах.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой 136 нэр төрлийн 509,865.8 мянган төгрөгийн дансны үнэтэй хөрөнгө байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3. “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1. “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ.” гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг УСНББОУС-17, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтад нийцүүлэн үнэлж шийдвэрлэх, бүртгэж тайлагнах.

3. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бараа материалын үлдэгдэл нь өмнөх оноос 43,474.4 мянган төгрөгөөр өссөн нь бараа материалын дансанд ашиглалтанд байгаа бараа материалыг бүртгэсэнтэй холбоотой байна.

Энэ нь үнэн зөв байдал, үнэлгээ ба хуваарилалт, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна УСНББОУС-12-ын “Зардлыг хүлээн зөвшөөрөх” 4 дэх заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Ашиглалтанд байгаа хөрөнгийг аж ахуйн материалыг УСНББОУС-12, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтад нийцүүлэн үнэлж шийдвэрлэх, бүртгэж тайлагнах.

4. Албан тушаалын нэршилтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Албан тушаалын тодорхойлолтод заасан ажил мэргэжлийн нэршил нь Боловсролын тухай хуулийн нэршлээс зөрүүтэй, албан тушаал нь мэргэжилтэн гэх боловч албан тушаалын тодорхойлолтод заасан ажлын чиг үүрэг нь туслах багш байна.

Энэ нь Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.2-д “... Хөдөлмөрийн онцлогийг харгалзан багшид ажлын 33, захирал, эрхлэгч, орлогч захирал, хичээлийн эрхлэгч /сургалтын менежер/, хичээлийн зохицуулагч, нийгмийн ажилтан, арга зүйч, дадлагын болон байрны багш, цэцэрлэгийн туслах багшид ажлын 15 өдрийн нэмэгдэл амралт тус тус олгоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Албан тушаалын тодорхойлолтод заасан ажил мэргэжлийн нэршлийг Боловсролын тухай хуулийн 43 дугаар заалттай нийцүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн мянган төгрөг		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																
1	Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль	АХГ-2022/39/НА-СТА-ТШЗ	Тус байгууллага нь нэмэлт санхүүжилтийн орлогоос төвлөрүүлсэн 439,368.8 мянган төгрөгийг зардлын дансанд бүртгэсэн	Нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайланг залруулсан	1	439,368.8	1	439,368.8								
2	Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль	АХГ-2022/39/НА-СТА-ТШЗ	Налайх дүүргийн нийгмийн даатгалын хэлтсээс 7,360.4 мянга, нийслэлийн татварын газраас авах суутган 6,713.7 мянган төгрөгийн илүү гооцоолж бүртгэсэн 14,074.5 мянган төгрөгийн авлага байна.		1	14,074.5								1	14074.5	
3	Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль	АХГ-2022/39/НА-СТА-ТШЗ	Бараа материалын үлдэгдэл нь өмнөх оноос 43,474.4 мянган төгрөгөөр өссөн байна. Өссөн шалтгаан нь бараа материалын дансанд ашиглалтанд байгаа бараа материалыг бүртгэсэнтэй холбоотой байна.		1									1		

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

4	Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль	АХГ-2022/39/НА-СТА-ТШЗ	Албан тушаалын годорхойлолтод заасан нэршил нь Боловсролын тухай хуулийн нэршлээс зөрүүтэй. Албан тушаал нь мэргэжилтэн гэх боловч албан тушаалын годорхойлолтод заасан ажлын чиг үүрэг нь туслах багш байна.		1										1	
5	Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль	АХГ-2022/39/НА-СТА-ТШЗ	Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө нөхсөн 509,865.8 мянган төгрөгийн дансны үнэтэй 136 ширхэг хөрөнгө байгааг стандарт, журмын дагуу шийдвэрлээгүй.		1										1	
Санхүүгийн тайлангийн аудитын дүн					5	453,443.3	1	439,368.8	0	0	0	0	0	0	4	14,074.5
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																
1	Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль	АХГ-2022/39/НА-СТА-ТШЗ	Шилэн дансанд 4,160,025.4 мянган төгрөгийн 96 мэдээлэл байршуулахаас 184,574.4 мянган төгрөгийн 13 мэдээллийг байршуулаагүй, орлогын 691,325.0 мянга, зарлагын 165.624.7 мянган төгрөгийн 14 мэдээлэл хоцроож байршуулсан.		1					1		1				
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлын дүн					1	0	0	0	0	0	1	0	1	0	0	0
Нийт дүн					6	453,443.3	1	439,368.8	0	0	1	0	1	0	4	14,074.5



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 111/А0/50058
АХГ-2022/39/НА-СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль нь 2021 онд нийт 4,160,025.4 мянган төгрөгийн 98 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 13 мэдээллийг ил тод байршуулаагүй, орлогын 856,549.7 мянган төгрөгийн нийт 14 мэдээллийг хугацаа хоцроож, өмнөх аудитаар илэрсэн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчлийг давтан гаргасан, аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заасныг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.2 "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй, өмнөх аудитаар албан шаардлага өгсөн зөрчлийг давтан гаргасан нягтлан бодогч Б.Мягмархүүд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг захирал Б.Батцэнгэлд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЮНИСТАР АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
М.ЭНХЖАРГАЛ

